



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/153


Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Инновацийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Онцгой байдлын байгууллагын Бүтээмжийн хөтөлбөрийн 4.1.3, Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө (2021-2024 он)-ий 2.3.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит жилийн эцсийн шалгалтын дүнд Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ажлын үзүүлэлтэд оруулж тооцохыг Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар (хурандаа Б.Батболд)-т даалгасугай.
4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (хурандаа Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.


ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г. АРИУНБУЯН

00001634

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн  
07 дугаар тушаалын хавсралт



## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭМЖИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр (цаашид хөтөлбөр гэх)-ийн 4.1.3-т заасан Бүтээмжийн хөтөлбөрийн зохион байгуулалт, зөвлөл, бүлэг, тэдгээрийн үйл ажиллагаа, эрх, үүргийг тогтооход оршино.

1.2. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандарт болон энэ журмыг мөрдлөг болгон, байгууллагын нийт алба хаагч, ажилтнуудын оролцоог бүрэн хангах зарчим баримтална.

### Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Бүтээмжийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт нь дараах шатлалтай байна. Үүнд:

2.1.1. Онцгой байдлын байгууллагын түвшинд Хөтөлбөрийн удирдах зөвлөл ажиллана. Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөл нь Хөтөлбөрийн удирдах зөвлөл (цаашид ХУЗ гэх) байна.

2.1.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, харьяа салбаруудын түвшинд Бүтээмжийн зөвлөл (цаашид БЗ гэх)-тэй байна.

2.1.2.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Бүтээмжийн зөвлөлийг Бүсийн төвийн дарга удирдана. БЗ-ийн бүрэлдэхүүнийг тухайн бүсийн Онцгой байдлын газраас тэнцүү төлөөллийг хангаж сонгоно.

2.1.2.2. Онцгой байдлын байгууллагын харьяа салбар, нэгжийн Бүтээмжийн зөвлөлийг тухайн нэгжийн дарга удирдана. Тухайн БЗ-ийн бүрэлдэхүүнийг нь байгууллагын бүтцийн нэгжээс тэнцүү төлөөллийг хангаж сонгоно.

2.1.2.3. Бүтээмжийн зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандарт хариуцсан мэргэжилтний аль нэг нь эсвэл БЗ-ийн бүрэлдэхүүнээс сонгогдсон алба хаагч Бүтээмжийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

2.1.3. БЗ-ийн нарийн бичгийн дарга нь хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарсан баримт бичгийг архивын хадгаламжийн нэгж үүсгэн бүрдүүлж, зохих журмын дагуу шилжүүлэх үүргийг хариуцна.

2.1.4. Бүтцийн нэгжийн түвшинд Бүтээмж, чанарын бүлэг (цаашид БЧБ гэх)-тэй байна. БЧБ-ийн ахлагчийг бүрэлдэхүүн дотроосоо хэлэлцэж сонгоно. БЧБ-т алба хаагч, ажилтнууд бүгд хамрагдсан байна. Нэг нэгжид хэд хэдэн БЧБ байж болно.

2.2. Хөтөлбөрийн удирдах зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.2.1. зөвлөх,

- 2.2.2. удирдлагаар хангах,
- 2.2.3. хяналт тавих,
- 2.2.4. шаардлагатай санхүүгийн асуудлыг шийдвэрлэх,
- 2.2.5. үр дүнг дэмжин урамшуулах шийдвэр гаргах.
- 2.3. Бүтээмжийн зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах үүрэгтэй оролцоно. Үүнд:
  - 2.3.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
  - 2.3.2. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
  - 2.3.3. Хөтөлбөртэй холбоотой аливаа асуудлаар удирдах зөвлөлд мэдээлэл хийх, санал уламжлах,
  - 2.3.4. Бүтээмж, чанарын бүлгүүдийн үйл ажиллагаанд эхний шатны үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.
  - 2.3.5. Бүтээлч санаа, санаачилгыг үнэлэх, урамшуулан идэвхжүүлэх;
  - 2.3.6. Шилдэг алба хаагч, манлайлагчдыг алдаршуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;
  - 2.3.7. Үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, хамт олноор хэлэлцүүлэх, үр дүнг гүйцэтгэлийн гол үзүүлэлттэй уялдуулах;
  - 2.3.8. Бүтээмжийн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшинг ахиулах, шинэлэг арга хэрэгслийг нэвтрүүлэх;
- 2.4. Бүтээмж чанарын бүлгүүд (цаашид БЧБ гэх) нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах үүрэгтэй оролцоно. Үүнд:
  - 2.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийн 5.3 ба 5.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 2.4.2. БЧБ нь бүтээмж, чанарыг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй үйл ажиллагаа явуулна.
  - 2.4.3. Бүлгийн явц, гүйцэтгэл, үр дүнгээ бүтээмжийн зөвлөл бусад холбогдох мэргэжлийн алба хаагчдад танилцуулж ажиллана.
- 2.5. Бүтээмжийн зөвлөл болон Бүтээмж чанарын бүлгээс тус журамд өөрчлөлт оруулах саналыг бичгээр Хөтөлбөрийн удирдах зөвлөлийн даргад гаргаж болно.
- 2.6. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын инновац, судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан бүтцийн нэгж арга зүйн заавар зөвлөгөө өгч, шаардлагатай гарын авлага, судалгааны материалаар ханган, дэмжлэг үзүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ажиллана.

### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл**

3.1. Хөтөлбөрийн 5.4.1 дэх “5 сайн зарчим” (цаашид 5С гэх)-ын үйл ажиллагаа:

3.1.1. “5С” гэдэг нь ажлын байрны зохион байгуулалт, нөхцөлийг сайжруулах, стандарт шаардлагыг тогтоон хэвшүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, алба хаагч, ажилтны сахилга батыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн цогц үйл ажиллагаа юм.

3.1.2. Алба хаагчид ажлын байрандаа хөтөлбөрийн 5.4.1-т заасан үйл ажиллагаа “5С”-ыг бүхэлд нь хэрэгжүүлнэ. Бүтээмжийн зөвлөл, бүтээмж, чанарын бүлгүүд нь ажлын байран дээр “5С”-ыг хэрэгжүүлэх, хэвшүүлэх чиглэлээр сайжруулалтын ажлыг зохион байгуулна.

3.1.3. Сайжруулалтын ажилд дараах төрлийн ажил хамаарна. Үүнд:

3.1.3.1. Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандартын 4, 10 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO45001:2018 стандартын 10.3 дахь заалтын хүрээнд хэрэгжүүлж болно.

3.1.3.2. ажлын байранд “5C”-ын аль нэгийг хэрэгжүүлсэн;

3.1.3.3. ажил хөнгөвчлөхөд чиглэгдсэн цар хүрээ багатай ажил.

3.2. Хөтөлбөрийн 5.4.2 дахь Сайн саналын систем (цаашид 3C гэх)-ийн үйл ажиллагаа:

3.2.1. Сайн саналын систем нь Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах зорилготойгоор алба хаагч, ажилтнуудаас гарах шинэлэг санаа, бодлыг нэгтгэх үйл явц байна.

3.2.2. “3C”-ээр алба хаагч, ажилтнууд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц шинэ санал санаачлагыг гаргана.

3.2.3. Санал гаргагч нь энэхүү журмын 1 дүгээр хавсралт дахь “Саналын хуудас”-ыг бөглөж, зардал үр дүнг тооцоход шаардлагатай анхан шатны өгөгдлүүд, холбогдох зураг, бичиг баримт, тооцоог хавсарган БЧБ-ийн ахлагчид хүлээлгэн өгнө.

3.2.4. Сайн саналыг түүний үр дүнгээс хамааруулан дэмжиж, урамшуулна.

### **Дөрөв. Сайн саналын системийн бүртгэл, мэдээлэл**

4.1. Алба хаагч, ажилтнуудаас ирсэн саналуудыг БЧБ-ийн ахлагч нь мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.2. Сайн саналын системээр ирүүлж буй саналыг дараах чиглэлээр ангилан бүртгэнэ. Үүнд:

4.2.1. Зохион байгуулалтын

4.2.2. Технологийн

4.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

4.2.4. Сайжруулсан ажил

4.2.5. Бусад

4.3. Бүтээмжийн зөвлөлөөс дараах санаачилгыг саналд тооцохгүй буцаана.

Үүнд:

4.3.1. Өмнө нь уг санал дэвшигдэж байсан;

4.3.2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд хийгдэж буй төлөвлөгөөт ажил;

4.3.3. ХАБЭА-ын нөхцөл болон бусад дүрэм журамтай зөрчилдсөн;

4.3.4. Өөрийн ажилд сайжруулалт хийгдэж байгаа боловч бусдад төвөг учруулахуйц;

4.4. Дараах саналыг БЧБ-ийн ахлагч тэмдэглэл хөтөлсний үндсэн дээр саналын нэгдсэн сангаас устгаж болно.

4.4.1. Мэдээлэл хангалтгүй, саналын боловсруулалт дутуу;

4.4.2. Гомдол, санал, хүсэлт, хувийн шинж чанартай асуудал.

### **Тав. 5 сайн зарчим “5C”, Сайн саналын систем “3C”-ийн үнэлгээ**

5.1. “5C”, “3C”-ийг БЧБ-ийн түвшинд сар бүр, БЗ-ийн түвшинд улирал тутам үнэлнэ.

5.2. БЗ нь шаардлагатай тохиолдолд “Сайн санал”-ыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой эсэхэд дүгнэлт гаргуулах хүсэлтийг Онцгой байдлын байгууллагын Техник, технологийн зөвлөлд гаргана. Техник, технологийн зөвлөл “Сайн санал”-д дүгнэлт гаргаж БУЗ-д уламжилна.

5.3. Бүтээмж чанарын бүлгийн ахлагч нэгдсэн санд мэдээллийг оруулж эхний шатны үнэлгээ хийн, дараагийн шатанд Бүтээмжийн зөвлөл үнэлнэ.

5.3. “5C” –ын үнэлгээ нь дараах хэлбэртэй байна.

5.3.1. явцын үнэлгээ: алба хаагч, ажилтан ажлын байрандаа “5С”-ыг хэрэгжүүлэх энэ журмын 2 дугаар хавсралт дахь “Сайжруулалтын ажлын хуудас”-аар дамжуулан доголдол зөрчлийг илрүүлж, арилгах арга замын талаар удирдлагадаа мэдээлнэ.

5.3.2. дүгнэлт үнэлгээ: БЧБ-ийн ахлагчийн үнэлгээ, ХАБЭА, ISO9001 стандартын хэрэгжилтийг хариуцсан ажилтны үзлэгээр ажлын байрны болон ажилтны хувийн соёлжилт “5С”-ийн хэрэгжилтэд дүгнэлт өгч, үнэлгээ хийн, сайжруулах зөвлөмжийг холбогдох нэгжийн удирдлагад илгээнэ.

5.4. “3С”-ийн үнэлгээ нь дараах хэлбэртэй байна.

5.4.1. “3С”-ээр ирүүлсэн саналуудыг дараах шалгуураар үнэлнэ. Үүнд:

- Шийдлийн нарийн түвэгтэй байдал – 20 хүртэл оноо
- Шинэлэг тал – 20 хүртэл оноо
- Цар хүрээ (бусад салбар, нэгжүүдэд нэвтрүүлэх боломжтой эсэх) – 10 хүртэл оноо
- Нийгэм, экологийн үр өгөөж – 20 хүртэл оноо
- Эдийн засгийн үр ашиг -30 хүртэл оноо

5.4.2. Сайн саналын үнэлгээнд БЗ-ийн гишүүдийн үнэлгээний дунджаар тухайн саналын үнэлгээг дараах шатлалын дагуу үнэлнэ.

- Маш сайн санал 81-100
- Сайн санал 61-80
- Энгийн санал 41-60
- Ач холбогдол бага санал 40 хүртэл

5.4.3. Сайн санал гаргагч нь алба хаагч бол саналын нэгдсэн үнэлгээг 1.0 гэсэн коэффициентоор, удирдах ажилтан, мэргэжилтэн бол 0.85 гэсэн коэффициентоор үржүүлж тооцно.

5.5. “5С”, “3С” хэрэгжилтийн үнэлгээ нь ХАБЭА, Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандартын хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт болно.

### **Зургаа. Сайн саналын хэрэгжилт**

6.1. Бүтээмжийн зөвлөлөөр үнэлэгдсэн саналын үр өгөөж, хэрэгжүүлэх боломжийг харгалзан анги, салбар, нэгжийн хэмжээнд эсвэл Бүтээмж, чанарын бүлгийн төсөлт ажлын хэлбэрээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ажлыг газар, анги, салбар, нэгжийн дарга, санал гаргагчид хариуцан зохион байгуулна. Шаардлагатай зураг төсөл, ашиглалтын зааврыг холбогдох нэгж, албан тушаалтан бэлтгэнэ.

6.2. БЧБ, БЗ-ийн үнэлгээгээр 61-80 оноо авсан саналыг Бүтээмж чанарын бүлгийн хүрээнд хэрэгжүүлж, илүү сайжруулах чиглэл хүргүүлнэ.

6.3. БЧБ, БЗ-ийн үнэлгээгээр 81-100 оноо авсан саналыг тухайн Бүтээмжийн зөвлөлийн хамрах хүрээнд хэрэгжүүлнэ.

6.4. БЗ-ийн түвшинд хэрэгжсэн сайн саналыг 6 сараас 1 жилийн хугацаанд хэрэгжүүлж БЗ эргэн хянаад, уг санал нь үр өгөөжтэй гэж үзсэн тохиолдолд дүгнэлт гаргах хүсэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Техник технологийн зөвлөлд уламжилна.

6.5. Техник технологийн зөвлөл нь дүгнэлт гаргуулах хүсэлт хүлээн авсан тохиолдолд тухайн саналтай холбогдох мэргэжлийн гишүүдээс бүрдсэн баг бүрдүүлж, ажлын 14 хоногт багтаан дүгнэлт гаргаж БУЗ-д уламжилна.

6.6. Хэрэгжсэн саналын үр дүнд тоног төхөөрөмж, ажил гүйцэтгэх арга барилд өөрчлөлт орсон, шинээр багаж хэрэгсэл, төхөөрөмж зохион бүтээж ашиглаж байгаа бол холбогдох дүрэм, заавар, стандартад энэ тухай өөрчлөлтийг тусгах, эсвэл баримт бичгийг шинээр боловсруулж батлуулах ажлыг Бүтээмжийн зөвлөл хариуцаж БУЗ-аар шийдвэрлүүлнэ.

## **Долоо. Бүтээмжийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах**

7.1. Бүтээмжийн үйл ажиллагааг дараах байдлаар дэмжиж, урамшуулна.

Үүнд:

7.1.1. Бүтээмж чанарын бүлгийн түвшинд "5С"-ын үнэлгээгээр 81-ээс дээш оноо авсан ажилтан, алба хаагчдад дотоодын урамшууллын механизмыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрдүүлж болно.

7.1.2. Бүтээмжийн зөвлөлийн түвшинд "3С"-ийн үнэлгээгээр 61-81 оноо авсан бол тухайн салбар, нэгж нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд урамшуулж, санхүүжүүлж болно.

7.1.3. Сайн саналын үнэлгээгээр 81-100 оноо авсан бол энэ журмын 6.5-д заасны дагуу Бүтээмжийн удирдах зөвлөлд уламжилж, БУЗ-ийн шийдвэрээр шаардлагатай санхүүжилт, дэмжлэгийг үзүүлнэ.

7.2. Бүтээмжийн үйл ажиллагааны жилийн үр дүнгээр үндэсний болон бүсийн түвшинд дараах чиглэлүүдээр шалгаруулан өргөмжилнө. Үүнд:

7.2.1. Шилдэг Бүтээмж чанарын бүлэг

7.2.2. Шилдэг Бүтээмжийн зөвлөл

7.2.3. Шилдэг сайн саналын төсөл

7.3. Шилдэг Бүтээмж чанарын бүлгийг БЗ, Шилдэг Бүтээмжийн зөвлөлийг ХУЗ жилд 1 удаа шалгаруулна. Шилдэг сайн саналын төслийн хэрэгжилтийн үр өгөөжөөс хамаарч Хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит Үндэсний шагналаар шагнаж болно.

7.4. Салбар, нэгж, алба хаагчдыг шагнах, урамшуулахад бүтээлч санал, санаачилга, оролцоог харгалзах бөгөөд онцгой амжилт үзүүлсэн алба хаагч, хамт олныг туршлага судлах багт оруулах, гадаад, дотоодын сургалт, семинар болон бусад арга хэмжээнд хамруулах зэргээр урамшуулна.

7.5. Сайн саналын төсөл, сайжруулах саналаар хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтийн урамшууллыг давхардуулж олгохгүй.

7.6. Бүтээмжийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах ажлыг хуульд нийцүүлэн хөтөлбөрийн 7-д заасан санхүүжилтийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

---oOo---

**Саналын хуудас**

№.....

Харьяалах салбар, нэгж .....  
Санал гаргагчийн овог, нэр .....  
Албан тушаал.....

.....он ..... сар ..... Өдөр

Саналын чиглэл: Ч (доогуур зур): Зохион байгуулалтын, Технологийн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Сайжруулсан ажил, Бусад

Асуудал: (санал хэрэгжүүлэхээс өмнөх байдал)

Шийдвэрлэх арга зам:

Хамтран хэрэгжүүлэгч: (алба хаагч, ажилтан эсвэл бүлэг)

Хэдий хугацаанд хэрэгжүүлэх боломжтой вэ?:

**САНАЛЫН ҮР ДҮН**

А. Саналыг хэрэгжүүлсний дараах байдал:

Нийгмийн үр дүн (ХАБЭА, хөдөлмөр зохион байгуулалт, ажиллах орчныг сайжруулсан, тасралтгүй ажиллагааг сайжруулсан, ажилтан, алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн гэх мэт.)

Эдийн засгийн үр дүн

Ажиллах хүч, Ажлын цаг хэмнэсэн эсэх:

Хэмнэлт гаргасан эсэх:

Ажлын бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлсэн:

Багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа уртассан эсэх:

Гадны байгууллагаас авдаг үнэ хэмнэсэн эсэх:

Бусад:

**Б. Саналыг хэрэгжүүлэхэд гарах зардлууд:**

Материал:

Ажиллах хүч (санал хэрэгжүүлэхэд оролцсон хүний тоо, ажилласан цаг):

Бусад:

**5 сайн зарчим “5С”-ыг хэрэгжүүлэх сайжруулалтын  
ажлын бүртгэлийн хуудас**

№.....

Бүтээмж чанарын бүлгийн нэр:					
Гишүүд:					
Сайжруулалтын ажлын агуулга:	Хэрэггүй зүйлийг устгахтай холбоотой сайжруулалт	Тогтсон байршилд байршуулахтай холбоотой сайжруулалт	“5С” хэвшүүлэлттэй холбоотой сайжруулалт	Асуудлын шалтгааныг арилгахтай холбоотой сайжруулалт	ХАБЭА-н стандарттай холбоотой сайжруулалт
...					
...					
...					

---oOo---